**Захиалгат ажлын тайлан**

Захиалагч: Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газар

Регистрийн дугаар:6125395

Гүйцэтгэгч: “Хэвлэлийн Хүрээлэн” ТББ

Регистрийн дугаар 1022601

Захиалгат ажил: Гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудын судалгаа

Гэрээний дугаар: 18/11-08

Захиалгат ажил эхэлсэн өдөр: 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Захиалгат ажлын явцын тайлан өгөх өдөр: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

# Гадаадад сурч, боловсрол эзэмшсэн залуучуудын судалгаа

## 1. Ерөнхий мэдээлэл

Монгол Улсад орчин үеийн боловсролын тогтолцоо үүсэн бий болоод 100 орчим жил болж байна. Олноо өргөгдсөн Монгол Улсын үеэс л монгол иргэдийг гадаад оронд явуулж боловсрол, мэргэжил эзэмшүүлж байсан бөгөөд 1921 онд Ардын хувьсгал ялж дэлхий дахинд социалист систем тогтсон үеэс тус системийн орнуудад боловсрол, мэргэжил эзэмших явдал эрс өсч, гадаад оронд мэргэжил эзэмшсэн мэргэжилтнүүд Монгол Улсын хэрэгцээт салбарт ажиллаж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулж байсан билээ. 1990 онд Монгол оронд Ардчилсан хувьсгал ялж улс төр, нийгмийн тогтолцоо өөрчлөгдснөөр боловсролын салбар ч мөн либералчлагдсан юм. Дэлхий дахинд социалист систем задран унаснаар зөвхөн системийн орнуудад боловсрол, мэргэжил эзэмшүүлэхээр илгээж байсан явдал үгүй болж, манай орны боловсролын системд эрс өөрчлөлт гарав.

1990-ээд оны дунд үеэс Монголын нийгэм, эдийн засгийн шинэчлэлийг дэмжих, түүний дотор боловсролын хөгжлийн шинэчлэлд тусламж дэмжлэг үзүүлэх сонирхолтой олон улсын байгууллага, гадаад орнуудын тоо өсч, үзүүлж байгаа тусламж дэмжлэгийн хэмжээ нэмэгдэж, боловсролын салбарын гадаад харилцаа өргөжиж эхэлсэн байна. Төрөөс ч Монгол Улсын боловсролын салбарт хийх өөрчлөлт, чиглэлийг батлан гаргав. Тухайлбал, Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 89 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл” –ийг баталсан бол Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2024 он/”-г батлан гаргажээ.

Мөн Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”, тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлийн жагсаалтыг баталсан байна. Энэхүү жагсаалтад:

**Магистр:** Боловсрол, Соёл, урлаг, Анагаах ухаан, эрүүл мэнд, Хөдөө аж ахуй, Эрчим хүч, дэд бүтэц, Уул уурхай, Зам тээвэр, Барилга, хот байгуулалт, Байгаль орчин, ногоон хөгжил, Мэдээллийг технологи, Суурь шинжлэх ухаан, тэргүүлэх технологи

**Доктор:** Боловсрол, Соёл, урлаг, Анагаах ухаан, эрүүл мэнд, Хөдөө аж ахуй, Эрчим хүч, дэд бүтэц, Байгаль орчин, ногоон хөгжил, Барилга, хот байгуулалт, Мэдээллийг технологи, Суурь шинжлэх ухаан, тэргүүлэх технологи хэмээн зааж өгсөн байдаг.

2017 онд УИХ-аас “Залуучуудын хөгжлийг дэмжих” тухай хуулийг баталж 2018 оноос энэхүү хууль хэрэгжиж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах үндсэн чиглэл, бодлогын баримт бичигт чөлөөт нийгмийн давуу талд тулгуурлан гадаад ертөнцөд боловсролын харилцааг бүрэн нээж, улмаар түүнийг олон улсын нийтлэг түвшинд хүргэхэд тэмүүлэх, боловсролыг сэтгэлгээний нь түвшингээр хөрвөх чадвартай болгох, өндөр хөгжилтэй орнуудад залуусыг сургах талаар тусгайлсан арга хэмжээ авах, гадаадын шинжлэх ухаан, боловсрол, соёлын нэр хүндтэй байгууллагуудад авьяас чадвартай залуусыг илгээн ажиллуулах боломжийг өргөжүүлнэ гэх зэргээр тодорхойлсон бөгөөд энэхүү бодлого чиглэлийн дагуу цөөнгүй Монгол залуус гадаадад суралцаж төгссөн байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Боловсролын зээлийн сангийн захирал Б.Лхагвасүрэнгийн мэдээлснээр “Төрийн сангийн зээлээр гадны оронд сургах докторын хөтөлбөр нь 1997 оноос эхлэн хэрэгжсэн. Бакалаварын хөтөлбөр 2011 оноос

эхлэн хэрэгжсэн. Магистр болон докторын зэрэгт нийт 2000 орчим оюутан суралцсан байдаг. Бакалаврын хөтөлбөрт 300-аад оюутан хамрагдсан байна”[1] (2018.05.09)

Төрийн дэмжлэгтэйгээр суралцахын сацуу гадаад улс орнуудын Засгийн газар хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу, бусад улс орнуудын Засгийн газар, их, дээд сургууль, коллежийн тэтгэлэгт хөтөлбөр, хувь хүн өөрийн зардлаараа гадаад оронд суралцаж боловсрол, мэргэжил олж авах байдал түгээмэл явдал болсон билээ.

Төр засгийн шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд гадаад оронд мэргэжил, боловсрол эзэмшсэн Монгол иргэдээ төрөлх эх орондоо ирж ажиллахыг уриалж, эзэмшсэн мэргэжил, олж авсан мэдлэгээ эх орныхоо хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад зориулахыг удаа дараа уриалж байсан. Энэхүү уриалгын дагуу ч эх орондоо буцан ирж ажиллаж байгаа залуус бий.

Харамсалтай нь гадаад оронд суралцагчдын талаарх мэдээлэл, статистик тоо баримт туйлын хомс байна. 1990 оноос хэдэн монгол залуус ямар оронд, ямар мэргэжлээр, хэдээс хэдэн онд, ямар зардлаар, хэрхэн суралцсан, хэд нь эргэн ирж, аль салбарт, ямар албан тушаалд ажиллаж байгаа талаарх нэгтгэсэн тоо, баримт мэдээлэл байхгүй байна.

Иймд Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын захиалгаар гадаад оронд боловсрол, мэргэжил эзэмшиж эх орондоо ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхлэхийг хүсэж байгаа хүмүүсийн дунд ажил эрхлэлт, нийгмийн байдал, хэрэгцээ шаардлагын талаарх судалгааг хэрэгжүүллээ.

[1] https://news.mn/r/778129/

## 2. Судалгааны түүвэр, мэдээлэл бүрдүүлэх аргачлал

Судалгаанд Улаанбаатар хот, орон нутагт ажиллаж, амьдарч байгаа гадаадад нийт 700 төгсөгчийг хамруулав. Мэдээллийг бүрдүүлэхдээ анкет-сурвалжлагын арга хэрэглэж, уламжлалт анкетийн аргыг цахим судалгааны аргатай хослуулан хэрэглэв.

Судалгаанд оролцогчдын нийгэм, хүн ам зүйн бүтцийг харуулбал:

**График 1: Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа**




**График 2: Судалгаанд оролцогчдын амьдарч буй газар**



**График 4: Судалгаанд оролцогчдын боловсрол**




**График 5: Судалгаанд оролцогчдын суралцсан улс орон**



Судалгаанд оролцогчдын 31.4% нь Монголд бүрэн дунд боловсрол эзэмшин шууд гадаад оронд суралцахаар явсан бол, 34.0% нь Монголын их, дээд сургуульд суралцаж байгаад гадаад оронд суралцахаар явсан байна.

Харин 31.4% нь Монголдоо боловсрол, мэргэжил эзэмшин ажиллаж байгаад гадаад орон суралцахаар явсан, 3.5% нь гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшин үргэлжлүүлэн суралцсан байна.

1990 оны Ардчилсан хувьсгалын дараагаар Монголын нийгэм, эдийн засгийн байдал хүнд, иргэдийн амьжиргааны түвшин тийм ч сайнгүй үед гадаад орны их дээд сургууль өөрийн тэтгэлэгт хөтөлбөртөө монголчуудыг хамруулах, сурагч, оюутнуудыг Засгийн газар хооронд байгуулсан гэрээний дагуу тэтгэлэгтэйгээр сургах ажлууд өрнөж эхэлсэн. Энэхүү байдал ч бидний хэрэгжүүлсэн судалгааны үр дүнгээр батлагдаж байна. Тухайлбал, энэ удаагийн судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 64.0% нь тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж гадаад оронд суралцсан байна. Манай улсын эдийн засаг, иргэдийн амьжиргааны түвшин сүүлийн жилүүдэд сэргэж эхэлсэн бөгөөд иргэд хувиараа гадаад улсад суралцах, төлбөрөө өөрөө бие даан төлөх боломжтой болж эхэлсэн. Энэ нь мөн судалгаанд оролцогчдын 31.2% нь хувийн зардлаар гадаад оронд суралцсан гэснээс тодорхой харагдаж байна. Судалгаанд оролцогчдын 2.1% нь төрийн сангийн зээлээр, 2.8% нь байгууллагын зардлаар гадаад оронд суралцжээ. Гадаад оронд суралцахдаа сургалтын төлбөрийг хэрхэн шийдсэн талаарх асуултад хариулсан байдлаас харахад анхаарал татсан зүйл нь Төрийн сангийн зээлээр суралцах явдал юм.

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуульд суралцагчдын талаарх асуудал нийгмийн анхаарлын төвд сүүлийн жилүүдэд орж ирж, энэ асуудлаар Авлигатай тэмцэх газраас 2017 онд ажлын хэсэг байгуулж, арга хэмжээ авахыг Боловсролын зээлийн санд үүрэг болгосон байдаг.

Тухайлбал, АТГ-ын ажлын хэсэг 2017 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яаманд (БСШУСЯ) ажиллаж, Боловсролын зээлийн сангийн зээлээр гадны оронд суралцсан иргэдийн судалгаатай нарийвчлан танилцсан юм. Улмаар Боловсролын зээлийн сан буюу хуучин нэршлээр Сургалтын төрийн сангаас зээл авч гадаад улсад суралцсан боловч сургуулиа төгсөөд бүртгүүлээгүй,

сураггүй болсон иргэдийн судалгааг илүү нарийвчлан гаргаж, буруутай этгээдээр хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шийдвэрлэж, нийтэд ил тод мэдээлэхийг үүрэг болгосон. Үүний дагуу Боловсролын зээлийн сан өөрийн албан ёсны цахим хуудсандаа 1997-2012 оны хооронд төрийн сангийн зээлээр гадаад улсад суралцсан ч гэрээний үүргээ биелүүлээгүй 393 иргэний нэрсийг зарласан юм.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Боловсролын зээлийн сангийн захирал П.Лхагвасүрэнгийн мэдээлснээр зээлд хамрагдан сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа нэг мянга гаруй хүн байгаа аж.

Бидний хэрэгжүүлсэн судалгааны дүнгээс харвал гадаад оронд боловсрол, мэргэжил эзэмшин Монголд буцаж ирэх болсон шалтгаанаа судалгаанд оролцогчдын 40.4% нь Монгол орныхоо хөгжилд хувь нэмэр оруулахыг хүссэн учраас гэж хариулсан бол 26.2% нь эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах зорилгоор, 23.4% нь найз нөхөд, гэр бүл Монголд байгаа учраас хэмээн тайлбарлажээ. Харин 5.6% нь сургалтын тэтгэлэг, санхүүжилтийн нөхцлийн дагуу заавал буцаж ирэх ёстой байсан, 3.5% нь ар гэрийн шалтгаанаар, 0.71% нь зээлээ төлөх шалтгаанаар Монголд буцаж иржээ.



Монгол орны хөгжилд хувь нэмрээ оруулахыг хүссэн учраас эх орондоо буцаж ирсэн гэсэн хариултыг сонгосон хүмүүсийн 55.2% нь хувийн хэвшилд ажиллаж байгаа бол 27.2% төрийн байгууллагад ажилладаг байна.




Гадаадад мэргэжил боловсрон эх орондоо буцан ирж, төрийн байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн 33.9% нь эрэгтэй, 18% нь эмэгтэйчүүд байна. Харин хувийн хэвшил, олон нийтийн/ иргэний нийгмийн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн хувьд хүйсийн харьцаа тэнцвэртэй байгаа бол олон улсын байгууллагад ажиллаж байгаа хүмүүсийн хувьд эмэгтэйчүүд давамгай байдалтай байна.



Судалгаанд оролцогчдын 66% нь гадаад оронд мэргэжил, боловсрол эзэмшиж ирээд эх орондоо ажиллахад хүндрэл, бэрхшээл тулгарсан гэсэн бол 22.7%-д нь ямар нэг хүндрэл бэрхшээл тулгараагүй аж.

Хүндрэл бэрхшээл тулгаарсан гэж хариулсан хүмүүсийг аль салбарт ажиллаж байгаагаар нь харьцуулан үзвэл 39.1% нь боловсролын салбарт, 17% нь уул уурхай, 13% нь барилга мөн аялал жуулчлалын салбарт ажиллагсад байна.




Энэхүү хүндрэл, бэрхшээлийн хамгийн гол шалтгаан нь цалин бага /34%/ гэсэн бол төрийн байгууллагын хүнд суртал их /17%/, ажиллах орчин тааруу /11%/, эзэмшсэн мэргэжлийн дагуу ажлын байр байхгүй /10%/, байгууллагын соёл таалагддаггүй /10%/, нийгмийн хамгааллын бодлого сул /10%/ гэсэн хүчин зүйлүүд удаалж байна. Мөн түүнчлэн тухайн байгууллагын удирдлагын арга барил таалагддаггүй /7.1%/, тухайн байгууллага хамт олны уур амьсгал таалагддаггүй /1.4%/ хүндрэл бэрхшээл тохиолддог аж. Судалгаанд оролцогчид мөн энэ талаар өөрчдийн санал хүсэлтээ дараах байдлаар илэрхийлжээ:

- *Дээр дурдсан бүх нөхцөл Монголын аль ч албан байгууллагуудад байдаг. Хүнд суртал залуу боловсон хүчнүүдээ дэмждэггүй, тусалдаггүй эсвэл гадаад*

*төгссөн гэсэн үүднээс бүгдийг чи хийх ёстой гэсэн үндэслэлээр ханддаг. Соёлгүй, хүндлэл байхгүй.*

- *Амьдрах орчин муу.*
- *Суралцсан хугацаанд НДШ байгууллага төлөөгүй нь маш том саад учруулж байгаа.*
- *Цалин бага, хүнд сурталтай.*
- *Авилгал маш их байдаг юм байна. Өндөр албан тушаалтан, танил талгүй хүн ажилд ороход маш бэрхшээлтэй. Аль нэг намын гишүүн байхгүй бол дарамт ихтэй, хэцүү.*
- *Цалингаас илүүтэйгүүр ямар ч боловсрол мэдлэггүй зүгээр арын хаалгаар орж ирсэн хүмүүс удирдлагад ажиллаж байдаг болохоор хэзээ ч санал нийлэхгүй. Мөн тэд өөрсдийн байр сууриа алдахгүйн төлөө үхэн хатан зүтгэдэг учраас тэдний доор ажиллана гэдэг зүгээр там. Хамгийн гол зүйл нь танил тал арын хаалга дээшээ ахих өсөн дэвжих гол түлхүүр болж өгдөг учраас цаанаасаа Монгол Улсын бүх л салбарт үнэн шудрага зүйл байхгүй болчихсон байна.*
- *Орох байсан орон тоонд төрийн томчуудын хүүхдүүд орсон.*
- *1. Төрийн стратеги, бодлого, мастер төлөвлөгөө урт, дунд богино хугацаанд тогтвортой хэрэгжих боломжгүй сонгуулийн шоу*
- *2. Монголд хөрөнгө оруулагч гадны хөрөнгө оруулагчид Монгол Улсын хуулийг хахууль өгөөд л зөрчдөг*
- *3. Төрийн болон бизнесийн байгууллагын топ менежментийн багт танил талаараа илүү ордог. Мэргэжлийн ажлаа мэддэг хүмүүс ажилладаггүй.*

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн тогтоолоор “Дэлхийн Монголчууд” хөтөлбөрийг баталсан байдаг. Энэхүү хөтөлбөрийг 2016-2020 онд хэрэгжүүлнэ гээд хилийн чанадад нарийн мэргэжил эзэмшсэн иргэдийн мэдлэг, боловсролыг ашиглах, монголд нутагших боломж, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр урт хугацааны тогтвортой бодлого зайлшгүй шаардлагатай байна гэжээ. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ хэсэгт:

“6.2.1. **гадаадад их, дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, гадаадад төгсөгчдийг ажлын байраар хангасан үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;**

**6.2.2. улсын төсөв, сургалтын сангийн зээлээр гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийг гэрээ байгуулсан төрийн захиргааны төв байгууллага ажлын байраар хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;**

**6.2.3. гадаад улсад нарийн мэргэжил эзэмшсэн иргэдийг түр хугацаагаар буюу бүрмөсөн эх орондоо ирж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх;**

**6.2.4. патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд монгол эрдэмтэд, өндөр мэргэжил эзэмшсэн иргэд, тэдний ажилладаг болон хамтран ажилладаг байгууллагыг татан оролцуулах;**

**6.2.5. холбогдох төрийн байгууллагатай хамтран гадаадад их, дээд сургууль төгсөгчдөд зориулсан хөдөлмөрийн яармагийг жил бүр тогтмол зохион байгуулах;**

**6.2.6. эх орондоо ирж суурьших иргэдийн нийгмийн даатгалын асуудлыг шийдвэрлэх, хувь хүний орлогын албан татвараас нэг удаа чөлөөлөх зэрэг эдийн засгийн хувьд таатай нөхцөл бүрдүүлэх” хэмээн тодорхойлсон байна.**

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ гадаадын их, дээд сургууль төгсөгч иргэдийг ажлын байраар хангасан тоо, эх орондоо түр хугацаагаар болон бүрмөсөн ирж, ажилласан нарийн мэргэжлийн эмч, шинжээч, эрдэмтдийн тоогоор хэмжинэ гэжээ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах үүрэг бүхий зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн дарга нь гадаад харилцааны асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн байна гэж зааж өгчээ.

Энэхүү хөтөлбөр нь гадаад оронд ажиллаж, амьдарч байгаа иргэд, гадаад оронд мэргэжил, боловсрол эзэмшсэн иргэдийг эх орондоо ажиллаж, хөдөлмөрлөх бололцоог зохицуулсан чухал ач холбогдолтой хөтөлбөр бөгөөд харин уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт – шинжилгээ, үнэлгээ, тайлан, тоо баримт хараахан олдохгүй байна.

Бидний хэрэгжүүлсэн судалгааны дүнгээс харвал судалгаанд оролцогчдын 55.3% нь буюу гадаадад суралцаж мэдлэг боловсрол эзэмшиж, эх орондоо ажил хөдөлмөр эрхэлж байгаа 2 хүн тутмын нэг нь хувийн хэвшилд ажиллаж байгаа аж. Харин 25% нь төрийн байгууллагад, 8% нь олон улсын байгууллагад, 4% нь олон нийтийн/ иргэний нийгмийн байгууллагад ажиллаж байна. Харин 7.8% нь одоогоор ажилгүй байна гэжээ.



Гадаад оронд мэргэжил боловсрол эзэмшин эх орондоо буцаж ирсэн ч одоогоор ажилгүй байгаа хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байна.




Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрийн тухайн үед хийж байсан мэдээллээр “2012 жилийн эцсийн дүнгээр эх орондоо эргэж ирээд Сургалтын төрийн санд бүртгүүлсэн, гэхдээ зээлийн гэрээ нь дуусгавар болоогүй 479 төгсөгчийн 332 нь төрийн байгууллагад, 112 нь хувийн хэвшилд ажиллаж жил бүр тайлангаа өгч тус сантай байнгын холбоотой байдаг бол 35 хүн одоогоор ажилгүй гэсэн бүртгэлтэй байгаа” аж.

Судалгаанд оролцогчдын 54% нь гадаад оронд эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу ажилладаг бол 33.3% нь эзэмшсэн мэргэжилтэйгээ яг шууд холбоотой биш боловч ойролцоо салбарт ажиллаж, 13% нь эзэмшсэн мэргэжлээрээ бус, өөр чиглэлээр ажиллаж байгаагаа илэрхийлжээ.

Гадаадад суралцаж мэргэжил, боловсрол эзэмшсэн хүмүүсийг эх орондоо ирж ажиллахад ямар хүчин зүйл хамгийн чухал гэж үздэг вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулжээ.Үүнд:

- *Ажлын байр нь тогтвортой залуучуудаа дэмждэг сонсдог хөгжүүлдэг урамшуулдаг. Мэдэхгүй зүйлийг зааж өгдөг байгаасай.*
- *Олон жил гадаадад амьдарсан хүмүүс Монголдоо буцаж ирээд дасан зохицох хэрэг гардаг. Монголын өнөөгийн нийгмийн байдал, хүмүүсийн харилцаа холбоо болон ёс жаягт дасах хэцүү байдаг.*
- *Ажлын байрны хүрэлцээ, цалингийн түвшин, шударга үнэлэмж*
- *Цалин, ажиллаж, судалгаа шинжилгээ хий өсч хөгжих боломжтой таатай орчин*
- *Мэргэжлийн ажлыг нь хийх боломжоор хангах, үнэлэх, урамшуулах*
- *Ажлын байрны судалгаа ил тод биш, Нарийн мэргэжлийн ажлын байрны дутагдал, хүнд суртал, удирдлагын явцуу бодол*
- *Ажлын байранд туршлага шаардахгүй байх*
- *Байгууллагын засаглал, цалин хөлс, сурч хөгжих боломж, шударга тогтолцоо, карьер өсөлт тодорхой байх*
- *Юун түрүүнд авлигагүй, хүнд сурталгүй байх. Хүний хөдөлмөрийг бодитоор дүгнэдэг байх. Төрийн албан хаагчийн тогтвортой мэргэшсэн байх баталгаа, нийгмийн, эрүүл мэндийн хамгааллын тогтвортой бодлого хүртээмжтэй үйлчилгээ, нийтийн тээврийн хүрэлцээ, эрүүл аюулгүй орчин баймаар байдаг.*
- *Төрийн оролцоо хэтэрхий их. 2. Цалин маш бага. 3. Байгууллагуудын соёл, удирдлага хөгжөөгүй.*
- *Цалин бага. Өсөх дэвжих боломж тааруу. Мерит систем байхгүй.*
- *Өөрийн зардал, цаг заваа зарцуулаад өндөр боловсрол эзэмшиж байхад илүү төрийн мастер план, бодлого тогтвортой байж бизнес хийх бодлого, дэмжлэг нь илүү бодит байж гаргасан шийдвэрүүд нь оновчтой байх мэргэжлийн шийдвэр гаргагч төрийн бодлого тодорхойлох менежментийн баг бүрдүүлдэг системийг бүрдүүлж төрийн бодлогуудыг зөв гаргадаг системийн бий болгож байж олон зүйл илүү бодит сайжрах боломжтой*

- *Нийгмийг эрүүл тогтолцоо, хууль дүрэм баримтлах, хариуцлага,цаг баримтлах*
- *Төрийн үйлчилгээний хүнд суртал , хамгийн наад зах нь цайны цагт төрийн үйлчилгээний ажилчид ээлжлээд цайгаа уудаг , цайны цагаар ямарч үед ажилладаг, үйлчилгээ үзүүлдэг байх хэрэгтэй санагддаг . Монголоос бусад бүх орны төрийн үйлчилгээ цайны цагаар нийтэд үйлчилдэг. Хариуцсан үйлчилгээний хүн нь цайнд явсан бол орлох үйлчилгээний хүнийг заавал байлгах гэх мэт... наад захын үйлчилгээ дутмаг байдгаас төрийн үйлчилгээ бүх шатандаа сэтгэл дутмаг , хүнд сурталтай байдлыг арилгаж чадвал бусад зүйлс аяндаа жигдэрнэ гэж боддог*
- *Холбогдох байгууллагуудын мэдээлэл ил тод байх,цогц дэмжлэг тусламж*
- *Шударга байдал, зөв үнэлэмжийг бий болгох. Өөрийн хүч чадлаар амжилтад хүрэх боломж бүрдүүлэх. Танил талаараа удирдах албан тушаалд очсон чадваргүй хүмүүс удирдлагад байгаа цагт шударга ажиллаж, хүч чадлаа гаргах хүсэл сонирхол төрөхгүй*
- *Ажлын орчин, байгууллагын соёл ёс зүй, ажилчдын хариуцлагатай байдал, удирдлага нь мэргэжлийн орчин үеийн, ажиллах хүч нь хэт хүн дээр төвлөрсөн бус сүүлийн үеийн дэвшилтэт технологийн шийдлүүдийг ашигладаг байх.*

Дээрх бүгдийг нэгтгэн үзвэл гадаадад суралцаж мэргэжил боловсрол эзэмшин эх орондоо ирж ажиллахад:

1. Цалин хөлс өндөр байх
2. Ажиллах, амьдрах таатай орчин бүрдүүлэх
3. Шударга байдал, бодитой үнэлэмж бий болгох нь хамгийн чухал гэж үзэж байна.

Гадаадад суралцаж мэргэжил боловсрол эзэмшин эргэн эх орондоо ирж ажиллахад хөгжлийн өөр түвшин, амьдралын хэв маяг, найз нөхдөөс хөндийрч тодорхой хугацаанд дасан зохицох зайлшгүй шаардлага тулгардаг. Үүнийг ч манай судалгаанд оролцогчийн “*Олон жил гадаадад амьдарсан хүмүүс Монголдоо буцаж ирээд дасан*

*зохицох хэрэг гардаг. Монголын өнөөгийн нийгмийн байдал, хүмүүсийн харилцаа холбоо болон ёс жаягт дасах хэцүү байдаг”* гэсэн хариултаас харж болно. Харин гадаадад төгсөгчид хоорондоо нэгдэн мэдээлэл, туршлага солилцох нь нийгэмд дасан зохицох, ажлын байрны мэдээлэл солилцох, сайн дурын үйл ажиллагаа явуулах гэх мэт эерэг үйл ажиллагааг явуулахад чухал хүчин зүйлийн нэг юм.

Бидний хэрэгжүүлсэн судалгааны үр дүнгээс харахад 48.2% нь гадаадад суралцаж төгсөгчдийн ямар нэг холбоонд гишүүнчлэлтэй, 52% нь гишүүнчлэлгүй гэжээ. Гишүүнчлэлтэй хүмүүс нь:

- БНХАУ-д төгсөгчдийн нэгдсэн холбоо
- Өвөр Монголд төгсөгчдийн нэгдсэн холбоо
- Хөх хотод төгсөгчдийн холбоо
- “Монгол-Германы гүүр” ТББ
- Туркэд төгсөгчдийн хамтын ажиллагааны нийгэмлэг /АТА/
- Эрхүүгийн төгсөгчдийн холбоо
- Вьетнамд төгсөгчдийн холбоо
- Монголоос ОХУ/ЗХУ-д сургууль төгсөгчдийн холбоо (МАВСУЗ)
- Тайваньд төгсөгчдийн холбоо
- Японд сургууль төгсөгчдийн ЖУГАМО нийгэмлэг
- БНСУ-д суралцагч Монгол оюутны холбоо /СМОХ/
- Монгол-Австрийн суралцагчдын холбоо
- Их Британид төгсөгчдийн холбоо /UK Alumni Association in Mongolia ТББ/
- Монгол дахь Ротар-ёнэяам тэтгэлэг төгсөгчдийн холбоо
- Австралид төгсөгч Монголчуудын холбоо-нд гишүүнчлэлтэй байна.

Ийнхүү гадаадад төгсөгчдийн болон мэргэжлийн холбоодын гишүүн болсноор дараах ач холбогдолтой байдаг хэмээн үзэж байна. Үүнд:

- *Хамтран сайн дурын ажил хийх, мэдээлэл солилцох*
- *Танилын хүрээгээ тэлж, туршлага солилцох*
- *Ажилгүй байгаа төгсөгчидөд ажлын байр санал болгодог*
- *Мэдээ, мэдээллийг түрүүлж авдаг*
- *Ажлын байрны боломж, гадаадад тэтгэлгээр суралцах гэх мэт мэдээлэл солилцох, хамтарч нийгэмд тустай үйл ажиллагаа явуулах*
- *Мэдээлэл харилцаа холбоо бий болж улмаар хамтын ажиллагаагаар дамжуулан өөрсдийн хувь нэмрийг нийгэмд тодорхой хэмжээнд хүрч ажиллахыг зорьдог. Нийгэмлэгийн гишүүн бүр бие биенээ дэмжих заавар зөвөлгөө өгч суралцах боломж олгодог*
- *Тус газарт ажиллаж амьдарч байсан хүмүүстэй холбоотой байж, соёл урлагын амьдрал болон бусад үйл ажиллагааг дэмжих*
- *Нийгэмлэгээрээ дамжин гишvvдтэйгээ холбоотой байх, нийгмийн идэвхтэй гишүүн байх*
- *Одоохондоо ач холбогдол нь тааруу байсан. Энэ судалгаанаас харахад ач - холбогдол өндөрсөх бололтой*
- *Нийгэмд шударга ёсыг тогтооход хувь нэмэр оруулах, өөрийгөө хөгжүүлэх, гишүүдийнхээ хөгжлийг дэмжих, хамтдаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлж хамтын ажиллагааг өргөжүүлэх*
- *Олон ач холбогдолтой, хэлээ мартахгүй байх, тархиа цэнэглэх, цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх*
- *1.Төрийн бусаар байгууллагаар дамжуулж нийгмийг илүү гэрэл гэгээтэй болгох ирээдүйг бэлтгэхэд өөрийн сурч мэдсэн ажлын болон амьдралын туршлагаасаа залуу үедээ сургамж урам өгөх, 2.нетворкинг*
- *Хэрэгтэй байх гэж бодож байна. Гадаад орны туршлагаас эх орны хөрсөнд буулгах, санаа оноогоо нэгтгэж том төсөл боловсруулахад хувь нэмэр оруулах гэх мэт олон талаар ач холбогдолтой гэж бодож байна*
- *Ажлаас гаднах бас нэг сайхан хамт олон болдог, гишүүддээ нийгэмд чиглэсэн арга хэмжээнүүд зохион байгуулдаг тул сонирхолтой.*

- *Үнэт зүйлс, алсын хараа нэгтэй бол сайн дурын үндсэн дээр ч аливаа ажлыг хийх боломж дүүрэн байдаг болохыг үргэлж хардаг, мөн хүн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлдэг. Үнэт зүйлс нэгтэй хүмүүсийн танилын хүрээ өргөждөг.*

Бидний хэрэгжүүлсэн судалгаанд оролцогчдын 2 хүн тутмын нэг нь дахин цаашид гадаадад суралцах, мэргэжил дээшлүүлэх бодолтой байгаа бол 11% нь тийм бодолгүй байгаа бөгөөд 39% нь тодорхой хэлж мэдэхгүй байгаагаа илэрхийлжээ.

## САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Улсын их хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Монгол Улсын их хурлаас "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай" 7 бүлэг 25 зүйл бүхий бие даасан, цогц хууль баталсан. Хуулийн хүрээнд залуучуудыг гадаадад мэргэжил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх, гадаадад сурч төгссөн залуучуудыг Монгол улсад ажиллах нөхцөл боломжоор хангах, тэднээр дамжуулан технологи суурьшуулах, хөгжих боломжийг нь хангах, оролцоог нь дэмжих, түүнийг зохион байгуулах талаар тодорхой зааж өгсөн.

Мөн Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6.6 Гадаадад сурч, ажиллаж, хөдөлмөрлөж байсан залуусыг дэмжиж, ажлын байраар хангах, хамтран ажиллах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгасан байдаг.

Мэргэжил боловсрол, эзэмшүүлэх талаар 9.1.2-д "залуучуудыг эх орондоо болон гадаад улсад мэргэжил эзэмших, мэргэших боломжийг бүрдүүлэх" хэмээн зааж өгсөн бол гадаадад суралцаж, төгссөн залуучуудын мэдлэг, боловсролыг өөрийн оронд нутагшуулах, улмаар хөгжилд хувь нэмэр оруулах тухай 11.1.3-д "гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх" гэсэн заалтыг оруулсан юм. Мөн өндөр мэргэжил эзэмшсэн залуучууд б уюу чадавх бүхий боловсон хүчний нөөцийг тогтоон барих, уг ажлыг эрхлэн гүйцэтгэх зохион байгуулалтын асуудлыг 11.1.5-д "гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон

залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх” гэж, залуучуудыг хөгжүүлэх, оролцоог нь хангах тухай 19.1.3 (залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах ), 20.1.7 (залуучуудын хөгжлийн чиглэлээр хууль тогтоомжийн хүрээнд гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах), 22.4.3 (залуучуудын хөгжлийг дэмжих асуудлаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах ) дахь заалтуудад тусгайлан тусгаж өгсөн.

Гадаадад сурч боловсролд эзэмшсэн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, улмаар нөөцийг нь үр бүтээлтэй ашиглах талаар ийнхүү хуульчлаад удаагүй байгаа ч бүс, орон нутгийн хэмжээнд, цаашлаад улс орны хөгжилд чиглэсэн бодитой, үр дүн өгөхүйц төсөл хөтөлбөр, бодлого, чиглэлийг тодруулах хэрэгцээ байгаа нь уг судалгааг хийх үндэслэл болсон.

Гадаадад төгсөгч залуучуудын боловсрол, мэдлэгийг үр бүтээлтэй ашиглах боломж, гарц, залуучуудад бодитой дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлох, залуучуудын оролцоотой хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл буюу бодлогын түвшний зорилт, хөтөлбөрийг дэвшүүлэн гаргахад судалгааны ажлын зорилго чиглэсэн бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлснээр бодитой үр дүнд хүрнэ.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Дэлхийн Монголчууд” /2016-2020/ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах. Ингэхдээ, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ хэсэгт заасанчлан:

- гадаадад их, дээд сургууль төгсөгчдийг ажлын байраар хангах, гадаадад төгсөгчдийг ажлын байраар хангасан үндэсний болон гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгох;
- улсын төсөв, сургалтын сангийн зээлээр гадаадын их, дээд сургуульд суралцаж төгссөн иргэдийг гэрээ байгуулсан төрийн захиргааны төв байгууллага ажлын байраар хангах эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- гадаад улсад нарийн мэргэжил эзэмшсэн иргэдийг түр хугацаагаар буюу бүрмөсөн эх орондоо ирж ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх;

- патент, өндөр технологи, инновацийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэхэд монгол эрдэмтэд, өндөр мэргэжил эзэмшсэн иргэд, тэдний ажилладаг болон хамтран ажилладаг байгууллагыг татан оролцуулах;

- холбогдох төрийн байгууллагатай хамтран гадаадад их, дээд сургууль төгсөгчдөд зориулсан хөдөлмөрийн яармагийг жил бүр тогтмол зохион байгуулах;

- эх орондоо ирж суурьших иргэдийн нийгмийн даатгалын асуудлыг шийдвэрлэх, хувь хүний орлогын албан татвараас нэг удаа чөлөөлөх зэрэг эдийн засгийн хувьд таатай нөхцөл бүрдүүлэх" ажлуудыг дэс дараатай зохион байгуулж, уг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, мэдээлэх шаардлагтай байна.

- Монгол Улсын БСШУСЯ, ГХЯ, Үндэсний Статистикийн Хороо болон холбогдох байгууллагууд гадаад улсад мэргэжил боловсрол эзэмшигчдийн тоон мэдээллийг тогтмол нэгтгэдэг байх,

- Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжихдээ хувь хүний хөгжил, боловсрол, соёл урлаг, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, аюулгүй амьдрах, хөгжих орчин гэсэн чиглэлээр зохион байгуулахаар Залуучуудын хөгжлийг дэмжих тухай Монгол Улсын хуулинд зааж өгсөн бөгөөд уг хуулийн хэрэгжилтийг хангах.

- Ялангуяа өндөр хөгжилтэй улс оронд суралцаж мэдлэг боловсрол эзэмшиж ирсэн иргэдийг "гадаад улсын тэргүүн туршлага, өндөр технологи, шинэ санааг үндэсний технологи болгон нутагшуулах, гарааны компани эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх" ;

- "Гадаад улсад өндөр технологи, нарийн мэргэжил, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо ажиллахыг дэмжих хөтөлбөрийг гадаад харилцааны болон залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлэх" заалтуудыг онцгой анхаарах,

- Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын залуучуудын хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах, хяналт-үнэлгээг тогтмол мэдээлж байх,

Өндөр хөгжилтэй улс оронд мастер, докторын зэрэг хамгаалсан эрдэмтэн, судлаачдыг Төрийн албан хаагчийн шалгалтаас чөлөөлөх эсхүл төрийн албанд ажиллах боломжийг нээж өгөх.

Хавсралт 1

## САНАЛ АСУУЛГЫН ХУУДАС

Танд энэ өдрийн мэнд хүргэе!

Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газраас гадаад оронд боловсрол, мэргэжил эзэмшиж эх орондоо ажил хөдөлмөр эрхэлж байгаа болон эрхлэхийг хүсэж байгаа хүмүүсийн дунд ажил эрхлэлт, нийгмийн байдал, хэрэгцээ шаардлагын талаарх энэхүү судалгааг явуулж байна. Иймд Та өөрийн сонгосон хариултын өмнөх дугаарыг дугуйлж тэмдэглэхээс гадна хоосон орхисон зайд санал, шүүмжлэл, сэтгэгдэлээ илэн далангүй бичнэ үү.

1. **<u>Та ямар чиглэлээр, аль оронд суралцсан бэ? /Хүснэгтэд нөхөж бичнэ үү/</u>**

| д/д | Улс орон | Хэдээс хэдэн он | Эзэмшсэн мэргэжил | Боловсрол, эрдмийн зэрэг |
|---|---|---|---|---|
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

2. **<u>Та гадаад улс оронд суралцахаар явахдаа,</u>**

   1. Монголд бүрэн дунд боловсрол эзэмшин шууд гадаад оронд суралцахаар явсан
   2. Монголын их, дээд сургуульд суралцаж байгаад гадаад оронд суралцахаар явсан
   3. Монголдоо боловсрол, мэргэжил эзэмшин ажиллаж байгаад гадаад оронд суралцахаар явсан
   4. Гадаадад бүрэн дунд боловсрол эзэмшин үргэлжлүүлэн суралцсан
   5. Өөр бусад ямар ..........................................................................................

3. **<u>Гадаад оронд суралцахдаа сургалтын төлбөрийг хэрхэн шийдсэн бэ?</u>**

   1. Хувийн зардлаар
   2. Төрийн сангийн зээл
   3. Байгууллагын зардлаар
   4. Тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаж
   5. Өөр бусад ямар …………………………………………………………….

4. **<u>Сургуулиа төгсөөд Монголд буцаж ирэх болсон шалтгаанаа тодорхойлно уу? (Өөрт хамаарах 1- 3 хариуг сонгож дугуйлна)</u>**

   1. Зээлээ төлөх
   2. Эзэмшсэн мэргэжлээрээ ажиллах зорилгоор
   3. Ар гэрийн шалтгаанаар

4. Найз нөхөд, гэр бүл Монголд байгаа учраас
5. Монгол орны хөгжилд хувь нэмэр оруулахыг хүссэн учраас
6. Сургалтын тэтгэлэг, санхүүжилтийн нөхцлийн дагуу заавал буцаж ирэх ёстой байсан учраас
7. Өөр бусад ямар......................................

**5. Мэргэжил, боловсрол эзэмшиж ирээд эх орондоо ажиллахад хүндрэл, бэрхшээл тулгарсан уу? Зөвхөн нэг хариулт сонгоно уу?**

1. тийм
2. үгүй
3. хэлж мэдэхгүй байна

**6. Хэрэв ТИЙМ гэсэн хариултыг сонгосон бол ямар хүндрэл бэрхшээл тулгарсан талаар тайлбарлана уу? Хамгийн чухал гэсэн 2-3 хариулт сонгоно уу.**

1. Цалин бага
2. Ажиллах орчин тааруу
3. Эзэмшсэн мэргэжлийн дагуу ажлын байр байхгүй
4. Төрийн байгууллагын хүнд суртал их
5. Тухайн байгууллагын удирдлагын арга барил таалагддаггүй
6. Тухайн байгууллага хамт олны уур амьсгал таалагддаггүй
7. Байгууллагын соёл, менежмент таалагддаггүй
8. Нийгмийн хамгааллын бодлого сул
9. Өөр бусад ямар/Бичнэ үү/

..............................................................................................

**8. Та эх орондоо ирээд аль салбарт ажиллаж байна вэ?**

1. төрийн
2. хувийн
3. олон нийтийн/иргэний нийгмийн
4. олон улсын
5. Одоогоор тодорхой ажилгүй байна

**9. Хэрэв ажил эрхэлж буй бол: Таны ажиллаж байгаа салбар эзэмшсэн мэргэжилтэй тань шууд холбоотой юу**

1. Тийм, мэргэжлээрээ ажиллаж байна.
2. Яг шууд холбоотой биш боловч ойролцоо салбарт ажиллаж байна
3. Эзэмшсэн мэргэжлээрээ бус, өөр чиглэлээр ажиллаж байгаа.

**10. Дараах жагсаалтаас Таны ажиллаж буй салбар аль нь вэ?**

1. Боловсрол
2. Соёл, урлаг
3. Хөдөө аж ахуй
4. Газар тариалан
5. Уул уурхай
6. Хэвлэл мэдээлэл
7. Барилга

8. Байгаль, экологи
9. Худалдаа
10. Аялал жуулчлал
11. Зочид буудал, нийтийн хоол
12. Өөр бусад ямар...........................................................

**11. <u>Таны бодлоор гадаадад суралцаж мэргэжил, боловсрол эзэмшсэн хүмүүсийг эх орондоо ирж ажиллахад ямар хүчин зүйл хамгийн чухал гэж үздэг вэ? /Бичнэ үү/</u>**

..........................................................................................................

..........................................................................................................

**12. <u>Гадаад суралцаж төгсөгчдийн ямар нэг холбоонд гишүүнчлэлтэй юу?</u>**

1. Тийм
2. Үгүй

**13. <u>Хэрэв Тийм бол холбооныхоо нэрийг бичнэ үү?</u>**

..........................................................................................................

..........................................................................................................

**14. <u>Хэрэв гишүүнчлэлтэй бол ямар ач холбогдолтой байдаг вэ?</u>**

